



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 0404

Баян-Өндөр сум

┌ Мөсний сурын аймгийн аварга ┐
шалгаруулах тэмцээнд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мөсний сурын 2025 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Тэмцээн зохион байгуулах, санхүүжүүлэх гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), үндэсний болон өвлийн спортын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (О.Заяа) нарт үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 1,030,000 (нэг сая гучин мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн
10/04/25 дугаар тушаалын хавсралт

2025 ОНЫ МӨСНИЙ СУРЫН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хүний тоо	Шагнал	Мөнгөн дүн
1	1-р байр	8	50,000	400,000
2	2-р байр	8	40,000	320,000
3	3-р байр	8	30,000	240,000
Дүн				960,000

№	Зардлын нэр	Ажиллах өдөр	Хүний тоо	1 өдрийн ажиллах хөлс	Бүгд
1	Шүүгч	1	7	10,000	70,000
Дүн					70,000

Төсвийн нийт дүн: 1,030,000 төгрөг

----oOo----